



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/52.


Улаанбаатар хот

### Нийслэлийн иргэдийн спортын VII наадмын софт волейболын шигшээ тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засгийн газрын 2009 оны 05, 2017 оны 289 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамжийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн спортын VII наадмын Софт волейболын шигшээ тэмцээнийг 2018 оны 11 дүгээр сарын 06-07-ны өдрүүдэд “Буянт-Ухаа” спортын ордонд зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.350.000 /Нэг сая гурван зуун тавин мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны спортын уралдаан тэмцээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн Б.Түвшинбаярт-үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2018 оны *10 дугаар* сарын *20* ны өдрийн *А/а* дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Нийслэлийн иргэдийн спортын VII наадмын софт волейбол шигшээ тэмцээн зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 5 x 50.000 төг = 250.000 төг 5 x 40.000 төг = 200.000 төг 5 x 30.000 төг = 150.000 төг	600.000
2.	Шүүгчдийн ажлын зардал: 5 хүн x 2 өдөр x 50.000 төг = 500.000 төг	500.000
3.	Өргөмжлөл	50.000
4.	Медаль: 15ш x 10.000 = 150.000 төг	150.000
5.	Анонс, цом	50.000
<b>ДҮН:</b>		<b>1.350.000</b>

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны  
даргын 2018 оны *10 дугаар* сарын *20*-ны өдрийн  
*А/С* дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Нийслэлийн иргэдийн спортын  
VII наадмын софт волейболын шигшээ  
тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүн

Ерөнхий шүүгч:  
Шүүгч

1. С.Мөнхдэлгэр
2. Л.Нацагдорж
3. Б.Баясгалан
4. С.Отгонбаатар
5. П.Пүрэв